



БОГД ХААНЫ ОРДОН МУЗЕЙН ЗАХИРАЛ
О.МЭНДСАЙХАН ТАНАА

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Бага тойруу 3, Засгийн газрын IV байр,
Утас: 26 04 37, Факс: (976) 6226 3230,
E-mail: info@audit.gov.mn, http://www.audit.mn

2017.02.23 № 3/361.
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Богд хааны ордон музейн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт, төсвийн гүйцэтгэлийн тайлан болон холбогдох бусад тайлбар тодруулга бүхий санхүүгийн тайланд аудит хийв.

Үүрэг хариуцлагын талаархи мэдээлэл

Богд хааны ордон музейн удирдлага нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Санхүүгийн тайлангууд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт (УСНББОУС), түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмын дагуу үнэн зөв, бодитой илэрхийлэгдсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Санал дүгнэлтийн үндэслэл

Бид аудитыг Аудитын олон улсын стандарт, түүнд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журмын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр стандарт, журмын шаардлага нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэх явдал болно.

Аудитаар санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем, тэгээрийг дэмжих нотлох зүйлийг сорилын үндсэн дээр шалгаж, удирдлагын хийсэн томоохон тооцооллыг үнэлж цэгнэн, санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулгыг үнэлсэн.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан материаллаг алдаагүй эсэхэд санал дүгнэлт өгөх хангалттай үндэслэл болно гэдэгт итгэлтэй байна.

Зөрчилгүй санал дүгнэлт

Богд хааны ордон музейн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж Сангийн сайдын баталсан бодлого, аргачлал, журмын дагуу материаллаг зүйлсийн хувьд үнэн, бодитой илэрхийлсэн байна.

САНХҮҮГИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

B. R

Ц.НАРАНЧИМЭГ



УАГ
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

**“БОГДХАН УУЛЫН ДАРХАН ЦААЗАТ
ГАЗРЫН ХАМГААЛАЛТЫН
ЗАХИРГАА” ТБАГУТУГ
ТӨСВИЙН 2016ОНЫ САНХҮҮГИЙН
ТАЙЛАН**

**Нэмэлт мэдээлэл авахыг хүсвэл
дараах хаягаар харилцана уу:**

Үндэсний аудитын газар:

ТАБ-ын Тэргүүлэх аудитор,
САГ-ын дарга: Ц.Наранчимэг
Утас: 261663

Аудитын менежер: Я.Самбууням
Утас: 260512

Аудитор: Ж.Болормаа
Утас: 261628

Үндэсний аудитын газар,
“Засгийн газрын IV байр”, УБ-46
Бага тойруу-6, Улаанбаатар хот,
Монгол Улс
Вэб: www.mnao.pmis.gov.mn

**Аудитыг гэрээгээр
гүйцэтгэсэн:**

“ОюуЭрдэм Аудит” ХХК

Захирал: Н.Цацрал
Утас: 94493362, 99101171

Е-мейл:
oyuerdem_audit@mongol.net
Улаанбаатар, Сүхбаатар
дүүрэг,
4-р хороо, “Түшиг” төв, 504
тоот

Аудитынтайлан

Хавсралт 1: Агуулга

Хавсралт 2: Аудитынгэрчилгээ

Хавсралт 3: Менежментийнзахидал

Хавсралт 4: Аудит хийсэн санхүүгийн
тайлан

Хавсралт 5: Төсвийн гүйцэтгэлийн тайлан

1. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл
2. Байгууллагын хууль, эрх зүйн орчин
3. Байгууллагын зорилго,үйлажиллагаа
4. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитын аргазүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн
5. Материаллагын байдлын түвшин
6. Дотоод хяналт
7. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар
8. Шилэн дансны мэдээлэл
9. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар
10. Гол, онцлог гүйлгээний талаарх тайлбар
11. Аудитаар илрүүлсэнголзөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:
12. Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:
13. Анхаарал татахуйц бусад чухал асуудал
14. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд
15. Санхүүгийн тайланд хийсэнаудитаарилэрсэнзөрчлийннэгтгэл
16. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт
17. Аудитын гэрчилгээний тохирох загварын талаарх дүгнэлт

1. Аудит хийх хууль эрх зүйн үндэслэл:

Монгол улсын төсвийн тухай хуулийн 8.9.1, Төрийн аудитын тухай хуулийн 15.1.2 дахь заалт, мөн хуулийн 18.5 дугаар зүйлд заасан заалтуудыг үндэслэн “Богдхан уулын дархан цаазат газрын хамгаалалтын захиргаа” ТБАГҮТҮГ-ынтөсвийн 2016 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон жилийн эцсийн санхүүгийн тайланд САГ-2017/250/СТА-ТШЗ аудит хийлээ.

АудитыгТөсвийн тухай, Төрийн аудитын тухай, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулиуд болон холбогдох бусад хууль, тогтоомжийн хүрээнд Аудитын Олон улсын стандартын зарчмуудад нийцүүлэн төлөвлөлтийн шатанд боловсруулсан төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явууллаа.

“Богдхан уулын дархан цаазат газрын хамгаалалтын захиргаа” ТБАГҮТҮГ-ын төсвийн 2016 оны санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн Олон улсын стандарт/УСНББОУС/, түүнд нийцүүлэн гаргасан улсын төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн захирагч санхүүгийн тайлангаа УСНББОУС, түүнд нийцүүлсэн Сангийн сайдын холбогдох журмууд, төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, Сангийн яамнаас зөвшөөрөл авсан НББ-ийн программ хангамжийн дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Тухайн санхүүгийн тайлан Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС-тай нийцүүлж материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

“Богдхан уулын дархан цаазат газрын хамгаалалтын захиргаа” ТБАГҮТҮГ-ын төсвийн 2016 оны санхүүгийн тайлангийн аудитыг 2017оны 01 дүгээр сарын 12-ноос 2017оны 02 дугаар сарын 20-ныг хүртэл хийхээр төлөвлөн хэрэгжүүлэв./ТАБ-СТА-А-9/

Оюу эрдэм аудит ХХК нь “Богдхан уулын дархан цаазат газрын хамгаалалтын захиргаа” ТБАГҮТҮГ-ын 2016 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан болон дагалдах тайлан судалгаануудыг 2017 оны 02 дугаар сарын 17-нд Үндэсний аудитын газартхүргүүлэв.

Үндэсний аудитын газар аудитыг 2017 оны 02 дугаар сарын 17-ноос 2017 оны 02 дугаар сарын 24-ний хооронд хянаж, аудитын тайланг 2017 оны 02 дугаар сарын 25-нд байгууллагын удирдлагад гардуулна.

2. Байгууллагын хууль, эрх зүйн орчин:

“Богдхан уулын дархан цаазат газрын хамгаалалтын захиргаа” ТБАГҮТҮГ-ын төсвийн захирагч нь Монгол Улсын “Төсвийн тухай”, “Төрийн болон орон нутгийн өмчийн тухай”, “Тусгай хамгаалалттай газар нутгийн тухай”хуулиудын хүрээнд үйл ажиллагаа явуулж байна. Тайлант онд тухайн байгууллагын үйл ажиллагаанд мөрддөг гол хууль, тогтоомжид өөрчлөлт ороогүй байна.

3. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа:

“Богдхан уулын дархан цаазат газрын хамгаалалтын захиргаа” ТБАГГУТҮГ нь Богдхан уулын дархан цаазат газрын экологийн тэнцвэрт байдлыг хадгалан байгалийн нөөц баялгийн хамгаалалт, ашиглалтын менежментийг зүй зохистой явуулах, Монгол улсын Тусгай хамгаалалттай газар нутгийн болон Байгаль орчны багц хуулиудын хэрэгжилтийг хангах үндсэн зорилготой.

Дээрх зорилтыг хэрэгжүүлэхийн тулд Монгол Улсын “Төсвийн тухай хууль”-ийн 16 дугаар зүйлийн 1-д “Төсвийн байгууллага нь түүний үйл ажиллагааг үр ашигтай удирдлагаар хангаж, ажлын үр дүнг хариуцах үүрэг бүхий төсвийн шууд захирагчтай байна” гэж заасан байна.

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 5-д “Агентлагийн дарга тус агентлагийн төсвийн шууд захирагч байна” гэж заасны дагуу “Богдхан уулын дархан цаазат газрын хамгаалалтын захиргаа” ТБАГГУТҮГ-ын даргаЦ.Ширэндэв төсвийн шууд захирагчийн үүргийг гүйцэтгэж байна. Төсвийн шууд захирагчийн төсвийг Сангийн яамны төрийн сангаас олгож байна.

Төсвийн захирагчийн үйл ажиллагаатай холбоотой хууль эрх зүйн орчин, байгууллагын үйл ажиллагааны онцлогийг аудитын горимын дагуу судалсан бөгөөд энэ талаар төлөвлөлтийн шатанд ТАБ-СТА-А-1 маягтад тодорхой тусгасан.

4. Аудитын шалгуур үзүүлэлт, аудитынаргазүй, хэрэгжүүлсэн горим, хяналтын сорил болон нарийвчилсан горим, түүний үр дүн:

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд,УСНББОУС, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг шалгуур болгон ашиглав.

Аудитаар Төсвийн захирагчийн төсвийн 2016 оны санхүүгийн тайланд дүгнэлт өгөх үүднээс төсвийн захирагчийн удирдлагын бэлтгэсэн санхүүгийн тайлан нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд төсвийн дансдын уламжлалт эрсдэл болон хяналтын эрсдэлийг тогтоон тухайн байгууллагын зүгээс тавьж буй дотоод хяналтыг үнэлж баримтжууллаа. /ТАБ-СТА-А-5/

Санхүүгийн тайланг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, зарим гүйлгээ ихтэй, голлох нөлөө бүхий, эрсдэлтэй байж болох томоохон дансдад түүвэрчилсэн байдлаар аудитын хяналтын 6горим, 57нарийвчилсан сорилыг гүйцэтгэв. /ТАБ-СТА-В-3/

Богдхан уулын дархан цаазат газрын хамгаалалтын захиргааны нягтлан бодох бүртгэлийн бодлого, системтэй танилцахад Монгол улсын Байгаль орчин, аялал жуулчлалын Сайдын 2009 оны 11 дүгээр сарын 30-ны өдрийн 365 тоот тушаалаар баталсан Төсвийн ерөнхийлөн захирагчийн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг санхүүгийн үйл ажиллагаанд мөрдөж ажиллаж байна. Энэхүү бүртгэлийн бодлогын баримт бичиг нь УСНББОУС-тай нийцсэн байна.

Төсвийн захирагчид ашиглагдаж байгаа компьютерийн системийн үйл ажиллагаатай асуулга явуулах аргаар танилцан түүний нарийн төвөгтэй байдлын үнэлгээг

хийхэд бага буюу мэдээллийн технологийн мэргэжилтэнг оролцуулах шаардлагагүй гэсэн үнэлгээ авсан тул аудитыг шууд гүйцэтгэлээ. /ТАБ-СТА-В-2/

Төсвийн захирагчийн санхүүгийн тайлангийн үйлажиллагааг бүртгэх, хянах, боловсруулах, бэлтгэхдээ Сангийн яамны тусгай зөвшөөрөлтэй “Санхүүгийн тооцоолох” ХХК-ийн “Acolous-3” санхүүгийн программаар санхүүгийн тайлан бэлтгэх аргачлалын дагуу гаргасан байна.

5. Материаллаг байдлын түвшин :

Төлөвлөлтийн үе шатанд нийт орлогыг материаллаг байдлын суурь болгон авч, түүний 1,0 хувиар тооцон материаллаг байдлын хэмжээг хагас жилийн санхүүгийн тайлангийн дүнг үндэслэн 1,793.7 мянган төгрөгөөр тогтоосон ба аудитын гүйцэтгэлийн үе шатанд жилийн эцсийн санхүүгийн тайлангийн дүнгээр нийт орлогын 1,0 хувиар буюу 4,484.8 мянган төгрөгөөр тогтоосон. /ТАБ-СТА-А-4/

6. Дотоод хяналт:

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа оршин байгаа эсэхийг нягтлах үүднээс дотоод хяналтын үйл явцыг ажиглан, асуулга авч, шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хийсэн. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалахын тулд жилийн турш үр нөлөөтэй ажиллах ёстой гол хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Төлөвлөлтийн үед “Богдхан уулын дархан цаазат газрын хамгаалалтын захиргаа” ТБАГУТУГ-ын НББ-ийн дотоод хяналтын эрсдлийг бага гэж тооцсон ба дахин хянаж үзэхэд дотоод хяналт хэвийн байна.

7. Төсвийн орлого, зардлын гүйцэтгэл, түүний талаарх тайлбар:

2016 оны батлагдсан төсвийг хуваарийн дагуу Сангийн яамны Төрийн сангийн харилцах дансаар дамжуулан санхүүжүүлснээс гадна төсвийн хүрээний мэдэгдлийг боловсруулах, төсвийн санхүүжилт, орлогын гүйцэтгэлийг хангах, төсвийн хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулж тайлагнахад байгууллагын удирдлагаас зохих хяналт тавин ажилласан байна.

Төсвийн захирагч нь 2016 онд улсын төсвөөс 377,844.7 мянган төгрөгийн санхүүжилт авахаас 377,576.8 мянган төгрөгийн санхүүжилт хүлээн авсан. Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих 20,000.0 мянган төгрөгийн төлөвлөгөөтэй ажиллахаас орлогын төлөвлөгөөг 100,0 хувь биелүүлж ажилласан байна.

Төсвийн гүйцэтгэлийн тайланд урсгал зардалд нийт 397,844.7 мянган төгрөг зарцуулахаас 366,444.5 мянган төгрөгийг зарцуулж, батлагдсан төсвийг 31,400.2 мянган төгрөгөөр хэмнэсэн байна.

8. Шилэн дансны мэдээлэл

“Шилэн дансны тухай хууль”-ийн дагуу төрийн өмчийн хөрөнгийг үр ашигтай захиран зарцуулах, төсвийн санхүүжилт, зарцуулалт, удирдлагын шийдвэр, үйл ажиллагааг ил тод, нээлттэй, ойлгомжтой байлгах, түүнд олон нийт хяналт тавих нөхцлийг бүрдүүлэх ажлын хэрэгжилтийг шалгаж үзэхэд “Богдхан уулын дархан цаазат газрын хамгаалалтын захиргаа” ТБАГУТУГ нь 2016 оны батлагдсан төсөв, төсвийн гүйцэтгэлийн тайланг өөрийн цахим хуудсаар болон www.shilendans.gov.mn нэгдсэн цахим хуудсаар нийтэд мэдээлсэн байна.

9. Олж тогтоосон гол эрсдэлүүд, түүний үр дагавар:

“Богдхан уулын дархан цаазат газрын хамгаалалтын захиргаа” ТБАГГУТУҮГ-ын үндсэн үйл ажиллагаа, хөрөнгө болон төсвийн зарцуулалтад холбогдох уламжлалт эрсдлийг бага гэж үнэлсэн бөгөөд үндсэн хөрөнгө, бараа материал, зардлын дансдын бүртгэл, ангилал, үнэлгээ, биет байдал, дотоод хяналтад холбогдох эрсдэл бага байна.

Аудитын төлөвлөгөөний дагуу аудитын 12 эрсдлийг тогтоож, батламж мэдэгдлүүдийн хүрээнд нийт 18горим,сорил гүйцэтгэв.

10. Гол, онцлог гүйлгээний талаарх (тохиромжтой бол) тайлбар:

“Богдхан уулын дархан цаазат газрын хамгаалалтын захиргаа” ТБАГГУТУҮГ-ын төсвийн 2016 оны санхүүгийн тайлан материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэдгийг, түүнийг бэлтгэн гаргахад баримталсан бодлого, зарчмуудыг үнэлж, аудитын явцад санхүүгийн тайланд нөлөөлөхүйц хэмжээний мөнгөн хөрөнгө, үндсэн хөрөнгө, бараа материал, зардлын дансдын ажил гүйлгээ, үлдэгдэл, тооцооллуудыг түүвэрчлэн нарийвчилсан сорилын аргаар шалгалаа. /ТАБ-СТА-В-3/

“Богдхан уулын дархан цаазат газрын хамгаалалтын захиргаа” ТБАГГУТУҮГ-д тайлант онд ямар нэгэн нэмэлт санхүүжилт хийгдээгүй тул онцлог гүйлгээ гараагүй байна.

11. Аудитаар илрүүлсэн гол зөрчлүүд, тэдгээрийг шийдвэрлэсэн талаар:

Санхүүгийн тайлангийн аудитаар хөндөгдсөн гол асуудлуудыг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв.

Материаллаг бус дараах зөрчил илэрсэн байна. Үүнд:

1. "Богдхан уулын дархан цаазат хамгаалалтын захиргаа" ТБАГУТУҮГ нь өөрийн байгууллагын онцлог байдлыг тусгасан нягтлан бодох бүртгэлийн бодлого боловсруулж мөрдөөгүй байна. Харин БОАЖЯ-наас 2009 онд үлгэрчлэн боловсруулсан "Төсвийн ерөнхийлөн захирагчийн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг"-ийг баримтлан нягтлан бодох бүртгэлээ хөтөлж байна.

Шийдвэрлэсэн: "Богдхан уулын дархан цаазат хамгаалалтын захиргаа" ТБАГУТУҮГ-ыг өөрийн байгууллагын онцлог байдлыг тусгасан нягтлан бодох бүртгэлийн бодлого боловсруулж мөрдөж ажиллах,

2. 2016 оны 12 дугаар сарын 31-нээрх санхүүгийн тайлангаар байгууллагын хөрөнгөнд нийт 65,625.77 мянган төгрөгийн элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн хөрөнгүүд байна.

Шийдвэрлэсэн:Өртгөө бүрэн нөхсөн хөрөнгийн талаар эрх бүхий удирдах дээд байгууллагынудирдлагад танилцуулж, цаашид ашиглагдах боломжтой хөрөнгийг дахин үнэлүүлж,бүртгэн, элэгдлийг тооцох,цаашид ашиглах боломжгүй хөрөнгийг данснаас хасуулах талаар санал оруулж, шийдвэрлүүлэх,

3. “Богдхан уулын дархан цаазат газрын хамгаалалтын захиргаа” ТБАГГУТУҮГ БОНХАЖЯ-наас тус хамгаалалтын захиргааны хяналтын төвийн байрыг нүүлгэн шилжүүлэх аж ахуйн хашаа, граж, агуулах барих зориулалтаар нэмэлт

санхүүжилтанд 43,000.0 мянган төгрөгийг Сангийн Яамны төрийн сангийн орлогын дансны хуулгаар нүүлгэлтийн зардал гэсэн гүйлгээний утгатай нэмэлт санхүүжилт 2015 оны 12 дугаар сарын 24 ны өдөр шилжиж ирсэн. “Богдхан уулын дархан цаазат газрын хамгаалалтын захиргаа” ТБАГТУҮГ 2015 оны 12 дугаар сарын 24 ны өдөр Дани ХХК-ийн Голомт банкин дахь 1601174409 тоот дансанд 5 тоот төлбөрийн хүсэлтээр 43,000.0 мянган төгрөгийг шилжүүлж, харилцах дансны кредитээс бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээ дансны дебетэд бүртгэсэн. 2015 оны санхүүгийн тайланд бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний дансыг 43,000.0 мянган төгрөгөөр орлого зарлагын нэгдсэн дансанд хааж буруу бүртгэсэн байна. Жич: 2016 оны 7 дугаар сарын 1 ний өдөр 43,000.0 мянган төгрөгийн үнэ бүхий граж, 20 тн-ын контейнер, хашаа, гүйдэг хаалга зэргийг хүлээн авсан байна.

Шийдвэрлэсэн: Тайлант онд дээрхи алдааг хуримтлагдсан ашгийн дансны кредитээсүндсэн хөрөнгийн дебетэд 43,000.0 мянган төгрөгийг залруулж бүртгүүлсэн.

4. Эхний хагас жилийн санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн гүйцэтгэлийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлангийн улсын төсвийн санхүүжилт 600.0 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасан байна.

Шийдвэрлэсэн: Төсвийн гүйцэтгэлийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлангийн улсын төсвийн санхүүжилт 600.0 мянган төгрөгөөр зөрүүтэй тайлагнасныг залруулсан.

5. Тайлант жилийн эцсийн байдлаар санхүүгийн тайланд 4,456.3 мянган төгрөгийн элэгдлийн зардлыг дутуу байгуулсан байна.

Шийдвэрлэсэн: Тайлант хугацааны элэгдлийн зардлыг 4,456.3 мянган төгрөгөөр дутуу илэрхийлснийг санхүүгийн тайланд залруулж тайлагнасан.

Аудитын явцад илэрсэн зөрчил дутагдлуудыг аудитын асуудлын бүртгэлд тусган байгууллагын удирдлагатай хэлэлцэн тохиролцож, эрсдэл ба аудиторын саналыг менежментийн захидлаар өгөх зөвлөмжид тусгахаар шийдвэрлэв. Илрүүлсэн зөрчлүүдээс шийдвэрлэхэд хүндрэлтэй зүйл байгаагүй бөгөөд шийдвэрлэлгүй үлдээсэн асуудал байхгүй болно.

12. Материаллаг бус залруулагдаагүй алдаануудын талаарх тайлбар:

Богдхан уулын дархан цаазат газрын хамгаалалтын захиргааны 2016 оны нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайланд материаллаг дүн бүхий буруу илэрхийлэл гараагүй учир залруулагдаагүй алдаа үлдээгүй болно.

13. Анхаарал татахуйц бусад чухал асуудал:

Анхаарал татахуйц чухал асуудалгүй байна.

14. Дараагийн аудитаар авч үзэх асуудлууд:

"Богдхан уулын дархан цаазат хамгаалалтын захиргаа"ТБАГТУҮГ-ын 2016 оны санхүүгийн тайлангийн аудитын явцад гүйцээж мөшгин шалгаж амжаагүй эрсдэлтэй асуудал гараагүй болно.

15. Санхүүгийн тайланд хийсэн аудитаар илэрсэн зөрчлийн нэгтгэл:

"Богдхан уулын дархан цаазат хамгаалалтын захиргаа" ТБАГУТУГ-ын төсвийн 2016 оны санхүүгийн тайланд хийсэн аудитаар нийт 113,682.1 мян төгрөгийн алдаа, зөрчил илэрсэн ба үүнээс 48,056.3 мян төгрөгийн зөрчлийг залруулж, 65,625.8 мян төгрөгийн зөрчилд зөвлөмж өглөө.

16. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт:

"Богдхан уулын дархан цаазат хамгаалалтын захиргаа" ТБАГУТУГ-ын төсвийн 2015 оны санхүүгийн тайланд манай компани аудит хийж гүйцэтгэсэн ба бид аудитаар Зөвлөмж өгсөн бөгөөд эдгээр зөвлөмжийн 67 хувийг хэрэгжүүлж, биелэлтийг гарган ирүүлсэн байна.

2016 оны эхний хагас жилийн санхүүгийн тайлангийн аудитаар нийт 6 зөвлөмж өгсөн бөгөөд зөвлөмжийн 67 хувийг хэрэгжүүлсэн байна.

17. Зөрчилгүй санал дүгнэлт:

Төсвийн захирагчийн тайлагнасан үлдэгдэл, ажилгүйлгээнүүд холбогдох хууль, УСНББОУС, түүнд нийцүүлэн Сангийн сайдын баталсан заавар, журмуудын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн байна.

Аудитлагдсан санхүүгийн тайлан 14 хуудас, байгууллагын санал 1 хуудсыг тус тус хавсаргав.



УАГ
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

**“БОГДХАН УУЛЫН ДАРХАН ЦААЗАТ
ГАЗРЫН ХАМГААЛАЛТЫН ЗАХИРГАА”
ТБАГУТУГ-ЫН ТӨСВИЙН
2016 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН
САНХҮҮГИЙН ТАЙЛАН**

Менежментийн захидал

Тэргүүлэх ач холбогдол №1 зүйлс:

Асуудал 1: НББ-ийн Бодлогын Баримт Бичгийн талаар

Асуудал 2: Үндсэн хөрөнгийн талаар

2016 он

Менежментийн захидал

“Оюу Эрдэм Аудит” ХХК аудитын явцад илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг Төсвийн шууд захирагчид зориулж бэлтгэсэн бөгөөд түүнд хяналтын султал, горимыг өөрчлөх замаар хяналтыг сайжруулах зөвлөмжийг өглөө.

Энэхүү менежментийн захидлын агуулга АОУС-ын дагуу хийгддэг ТАБ-ын аудитын горимоос урган гарсан болно. Бидний хэрэгжүүлсэн горим, сорил нь санхүүгийн тайлангийн санал дүгнэлт гаргахад зориулагдсан.

Тиймээс аудитын зөвлөмж нь дахин хяналт хийх үеийн нөхцөл байдлын талаархи бидний үнэлэлт, дүгнэлтийг тусгаж байгаа болно.

Төрийн аудитын байгууллага энэхүү зөвлөмжийг та бүхний бүртгэл, тайлагнал, хяналтын үйл ажиллагааг сайжруулах зорилготой бөгөөд харин зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан төсвийн захирагчийн холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

Асуудал 1: НББ-ийн Бодлогын Баримт Бичгийн талаар

Тэргүүлэхачхолбогдол №1

ҮАГ-ынажиглалт

"Богдхан уулын дархан цаазат хамгаалалтын захиргаа" ТБАГУТУГ нь байгууллагын онцлог байдлыг тусгасан нягтлан бодох бүртгэлийн бодлого боловсруулж мөрдөөгүй байна. Харин БОНХАЖЯ наас 2009 онд үлгэрчлэн боловсруулсан "Төсвийн ерөнхийлөн захирагчийн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг"-ийг баримтлан нягтлан бодох бүртгэлдээ хөтөлж байна.

Эрсдэлүүд

НББ-ийн тухай хууль зөрчигдөх;

ҮАГ-ынзөвлөмж

"Богдхан уулын дархан цаазат хамгаалалтын захиргаа" ТБАГУТУГ-ыг өөрийн байгууллагын онцлог байдлыг тусгасан нягтлан бодох бүртгэлийн бодлого боловсруулж мөрдөж ажиллах,

Үйлчлүүлэгчийн хариу

Аудитаар илэрсэн энэхүү алдаа, зөрчил дутагдлыг төсвийн захирагч хүлээн зөвшөөрсөн болно.

Асуудал 2: Үндсэн хөрөнгө, элэгдлийн талаар

Тэргүүлэхачхолбогдол №1

ҮАГ-ынажиглалт

2016 оны 12 дугаар сарын 30-ний байдлаарх санхүүгийн тайланд нийт 65,625.77 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн байна.

Эрсдэлүүд

НББОУС, НББ-ийн тухай хууль, НББ-ийн заавар журам зөрчигдөх;

ҮАГ-ынзөвлөмж

Өртгөө бүрэн нөхсөн хөрөнгийн талаар эрх бүхий удирдах дээд байгууллагын удирдлагад танилцуулж, цаашид ашиглагдах боломжтой хөрөнгийг дахин үнэлүүлж, бүртгэн, элэгдлийг тооцох, цаашид ашиглах боломжгүй хөрөнгийг данснаас хасуулах талаар санал оруулж, шийдвэрлүүлэх,

Үйлчлүүлэгчийнхариу

Аудитаар илэрсэн энэхүү алдаа, зөрчил дутагдлыг төсвийн захирагч хүлээн зөвшөөрсөн болно.

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН
2016 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/ төгрөгөөр/		
Балансын зүйл	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	-
Кассанд байгаа бэлэн мөнгө	-	-
Банк дахь харилцах данс	-	-
АВЛАГА	-	-
Байгууллагаас авах авлага	-	-
Хувь хүмүүсээс авах авлага	-	-
БАРАА МАТЕРИАЛ	64,265,203.91	67,910,334.43
Хангамжийн материал	41,265,203.91	42,860,334.43
Бичиг хэргийн материал	2,471,500.00	2,584,500.00
Аж ахуйн материал	6,887,556.00	6,734,756.00
Түлш, шатах тослох материал	349,537.48	221,500.00
Бусад хангамжийн материал	31,556,610.43	33,319,578.43
Биологийн хөрөнгө	-	24,450,000.00
Мал амьтад	23,000,000.00	600,000.00
ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	64,265,203.91	67,910,334.43
ҮНДСЭН ХӨРӨНГӨ	430,384,595.90	420,631,211.73
Биет хөрөнгө	430,384,595.90	420,631,211.73
Барилга, байгууламж, орон сууц	395,572,304.30	438,572,304.30
Барилга, байгууламж, орон сууц (Хуримтлагдсан элэгдэл)	(91,965,608.88)	(109,894,786.86)
Авто-тээврийн хэрэгсэл	180,563,209.85	182,088,209.85
Авто-тээврийн хэрэгсэл (Хуримтлагдсан элэгдэл)	(86,513,074.79)	(114,521,535.66)
Машин тоног төхөөрөмж	45,636,949.13	45,636,949.13
Машин тоног төхөөрөмж (Хуримтлагдсан элэгдэл)	(21,416,746.87)	(28,354,755.31)
Тавилга, аж ахуйн эд хогшил	17,368,857.40	17,368,857.40
Тавилга, аж ахуйн эд хогшил (Хуримтлагдсан элэгдэл)	(8,861,294.24)	(10,264,031.12)
Бусад үндсэн хөрөнгө	4,748,390.00	4,748,390.00
Бусад үндсэн хөрөнгө (Хуримтлагдсан элэгдэл)	(4,748,390.00)	(4,748,390.00)
Биет бус хөрөнгө	-	-
Програм хангамж	495,000.00	495,000.00
Програм хангамжийн хасагдуулга	(495,000.00)	(495,000.00)
ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	430,384,595.90	420,631,211.73
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	494,649,799.81	488,541,546.16
ӨР ТӨЛБӨР	-	-
Ажилчидтай холбогдсон тооцоо	-	-
Цалингийн өглөг	-	-
НДШ-ийн өглөг	-	-
НИЙТ ӨР ТӨЛБӨРИЙН ДҮН	-	-
Засгийн газрын оруулсан капитал	461,573,092.36	461,573,092.36
Өмнөх үеийн үр дүн	10,322,156.76	53,322,156.76
Тайлант үеийн үр дүн	-	(49,108,253.65)
Дахин үнэлгээний зөрүү	22,754,550.69	22,754,550.69
ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ ӨМЧИЙН ДҮН	494,649,799.81	488,541,546.16
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ ӨМЧИЙН ДҮН	494,649,799.81	488,541,546.16

ТӨСВИЙН ШУУД
ЗАХИРАГЧИЙН
2016 ОНЫ САНХҮҮГИЙН

АУДИТ ХИЙСЭН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
ТУСЛАМЖ САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	426,158,879.71	377,576,800.00
Улсын төсвөөс	370,434,246.00	377,576,800.00
Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	364,812,760.00	377,576,800.00
Хөрөнгийн орлого	5,621,486.00	-
Нэмэлт санхүүжилтийн орлого	55,724,633.71	-
Дээд шатны төсвийн захирагчаас төсөвт	53,000,000.00	-
Төсвийн урамшуулал	2,724,633.71	-
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	73,722,142.68	28,594,835.00
Бараа, үйлчилгээний орлого	73,722,142.68	26,453,728.00
Үндсэн үйл ажиллагааны орлого	17,603,623.00	20,000,140.00
Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	56,118,519.68	6,453,588.00
Бусад орлого	-	2,141,107.00
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН	499,881,022.39	406,171,635.00
УРСГАЛ ЗАРДАЛ	478,747,295.15	407,683,389.00
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	478,747,295.15	407,683,389.00
АЖИЛЛАГСАДТАЙ ХОЛБООТОЙ ЗАРДАЛ	327,694,558.06	316,479,567.58
Үндсэн болон нэмэгдэл цалин	293,981,159.86	284,745,075.53
Үндсэн цалин	285,427,559.86	284,745,075.53
Унаа, болон бусад нөхөн олговор	8,553,600.00	-
Нийгмийн хамгааллын шимтгэл	33,713,398.20	31,734,492.05
Тэтгэвэрийн даатгалын шимтгэл	21,966,986.12	20,113,480.24
Тэтгэмжийн даатгалын шимтгэл	2,349,282.42	2,509,169.45
ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	2,936,602.27	2,812,743.49
Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	587,320.85	569,490.39
Эрүүл мэндийн даатгалын хураамж	5,873,206.54	5,729,608.48
Байр ашиглахтай холбоотой тогтмол зардал	14,361,390.93	5,561,785.09
Гэрэл цахилгааны зардал	2,729,526.00	1,627,400.00
Түлш, халаалтын зардал	7,012,733.13	2,399,202.27
Цэвэр, бохир усны зардал	457,131.80	710,182.82
Байрны түрээс	4,162,000.00	825,000.00
Хангамж, бараа материалын зардал	11,280,807.06	16,307,195.95
Бичиг хэргийн зардал	1,359,178.00	1,118,700.00
Тээвэр, шатахууны зардал	7,465,462.52	7,884,537.46
Шуудан холбоо интернетийн төлбөр	1,995,246.54	2,012,738.49
Ном, хэвлэл захиалах, худалдан авах зардал	104,600.00	-
Бага үнэтэй түргэн элэгдэх зүйлс	356,320.00	2,459,600.00
Аж ахуйн материал худалдан авах зардал	-	2,831,620.00
Нормативт зардал	3,315,000.00	600,000.00
Нормын хувцас, зөөлөн эдлэл худалдан авах	3,315,000.00	600,000.00
Эд хогшил, урсгал засварын зардал	639,210.00	1,527,000.00
Багаж хэрэгсэл	-	18,500.00
Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	-	720,000.00
Урсгал засвар	639,210.00	788,500.00
Томилолт, зочны зардал	7,237,020.00	2,057,000.00
Дотоод томилолт	7,237,020.00	2,057,000.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний	60,719,690.00	9,005,360.00
Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил,	58,547,740.00	6,700,000.00
Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох	1,500,000.00	1,500,000.00
Даатгалын үйлчилгээний төлбөр	282,450.00	297,360.00
Тээврийн хэрэгслийн татвар	321,000.00	321,000.00
Тээврийн хэрэгслийн оношилгоо	68,500.00	187,000.00

Бараа үйлчилгээний бусад зардал	53,499,619.10	56,145,480.38
Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	45,555,300.87	54,278,384.17
Бусад зардал	7,944,318.23	1,867,096.21
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	16,077,943.18	47,596,499.65
Бусад урсгал шилжүүлэг	11,418,550.00	16,464,038.00
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж,	11,418,550.00	-
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн тэтгэмж	-	16,464,038.00
Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	4,659,393.18	31,132,461.65
Төвлөрүүлэх шилжүүлэг	4,659,393.18	31,132,461.65
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	494,825,238.33	455,279,888.65
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН	5,055,784.06	(49,108,253.65)
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ОРЛОГО	-	-
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДАЛ		
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН	5,055,784.06	(49,108,253.65)

БХУДЦГХЗ/СТ-3А

АУДИТ ХИЙСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

				/ төгрөгөөр/
Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Хөрөнгийн дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан үр дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
2015 оны 01 дүгээр сарын 01-нээрх үлдэгдэл	461,573,092.36	22,754,550.69	5,266,372.70	489,594,015.75
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				-
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	461,573,092.36	22,754,550.69	5,266,372.70	489,594,015.75
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт				-
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт				-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				-
Тайлант үеийн үр дүн			5,055,784.06	5,055,784.06
2015 оны 12 дугаар сарын 31-нээрх үлдэгдэл	461,573,092.36	22,754,550.69	10,322,156.76	494,649,799.81
Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			43,000,000.00	43,000,000.00
Дахин илэрхийлсэн үлдэгдэл	461,573,092.36	22,754,550.69	53,322,156.76	537,649,799.81
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт				-
Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт				-
Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз				-
Тайлант үеийн үр дүн			(49,108,253.65)	(49,108,253.65)
2016 оны 12 дугаар сарын 31-нээрх үлдэгдэл	461,573,092.36	22,754,550.69	4,213,903.11	488,541,546.16

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН
2016 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

АУДИТ ХИЙСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/ төгрөгөөр/

ҮЗҮҮЛЭЛТ	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	420,537,393.71	377,576,800.00
Улсын төсвөөс	364,812,760.00	377,576,800.00
Урсгал	364,812,760.00	377,576,800.00
Нэмэлт санхүүжилтийн орлого	55,724,633.71	-
Нэмэлт санхүүжилтийн орлого	53,000,000.00	-
Төсвийн урамшуулал	2,724,633.71	-
Бараа үйлчилгээний орлого	17,603,623.00	20,000,140.00
Үндсэн үйл ажиллагааны орлого	17,603,623.00	20,000,140.00
Үндсэн бус үйл ажиллагааны орлого	-	-
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	438,141,016.71	397,576,940.00
УРСГАЛ ЗАРДАЛ	438,141,016.71	397,576,940.00
БАРАА АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	420,691,017.57	349,980,440.35
Үндсэн болон нэмэгдэл цалин	294,171,581.16	286,019,102.74
Үндсэн цалин	285,617,981.16	265,905,502.74
Гэрээт ажлын хөлс	-	10,000,000.00
Унаа хоолны хөнгөлөлт	8,553,600.00	10,113,600.00
Ажил олгогчоос нийгмийн даатгалын шимтгэлд	32,150,920.94	31,636,454.03
Тэтгэвэрийн даатгалын шимтгэл	22,498,790.94	20,214,395.11
Тэтгэмжийн даатгалын шимтгэл	1,930,427.00	2,310,216.59
ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	2,413,031.00	2,924,007.50
Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	482,606.00	492,933.37
Эрүүл мэндийн даатгалын хураамж	4,826,066.00	5,694,901.46
БАРАА, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ УРСГАЛ ЗАРДАЛ	94,368,515.47	32,324,883.58
Байр ашиглахтай холбоотой тогтмол зардал	14,361,390.93	7,080,785.09
Гэрэл цахилгааны зардал	2,729,526.00	3,146,400.00
Түлш, халаалтын зардал	7,012,733.13	2,399,202.27
Цэвэр, бохир усны зардал	457,131.80	710,182.82
Байрны түрээс	4,162,000.00	825,000.00
Хангамж, бараа материалын зардал	11,409,464.54	11,649,738.49
Бичиг хэргийн зардал	1,045,578.00	1,231,700.00
Тээвэр, шатахууны зардал	7,815,000.00	7,756,500.00
Шуудан, холбоо, интернетийн зардал	1,995,246.54	2,012,738.49
Ном, хэвлэл захиалах, худалдан авах зардал	104,600.00	-
Бага үнэтэй түргэн элэгдэх зүйлс	449,040.00	648,800.00
Норматив зардал	-	600,000.00
Нормын хувцас, зөөлөн эдлэл	-	600,000.00
Эд хогшил, урсгал засварын зардал	599,210.00	1,552,000.00
Багаж техник хэрэгсэл	-	43,500.00
Хөдөлмөр хамгааллийн хэрэгсэл	-	720,000.00
Урсгал засвар	599,210.00	788,500.00
Томилолт	7,237,020.00	2,057,000.00

Дотоод албан томилолт	7,237,020.00	2,057,000.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	60,761,430.00	9,385,360.00
Бусдаар гүйцэтгүүлсэн нийтлэг ажил, үйлчилгээ	58,589,480.00	7,080,000.00
Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох	1,500,000.00	1,500,000.00
Даатгалын үйлчилгээний төлбөр	282,450.00	297,360.00
Тээврийн хэрэгслийн татвар	321,000.00	321,000.00
Тээврийн хэрэгслийн оношилгоо	68,500.00	187,000.00
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	17,449,999.14	47,596,499.65
Бусад урсгал шилжүүлэг	12,790,605.96	16,464,038.00
Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	12,790,605.96	-
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн урамшуулал	-	16,464,038.00
Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	4,659,393.18	31,132,461.65
Төвлөрүүлэх шилжүүлэг	4,659,393.18	31,132,461.65
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (II)	438,141,016.71	397,576,940.00
ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-	-	-
НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	-	-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН
2016 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр/

АУДИТ ХИЙСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

ҮЗҮҮЛЭЛТ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	397,844,700.00	366,444,478.35	31,400,221.65	92.1%
НИЙТ ЗАРЛАГЫН ДҮН	397,844,700.00	366,444,478.35	31,400,221.65	92.1%
УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	397,844,700.00	366,444,478.35	31,400,221.65	92.1%
Бараа үйлчилгээний зардал	353,495,800.00	349,980,440.35	3,515,359.65	99.0%
Ажиллагсадтай холбоотой зардал	288,931,800.00	286,019,102.74	2,912,697.26	99.0%
Үндсэн цалин	268,818,200.00	265,905,502.74	2,912,697.26	98.9%
Унаа болон бусад нөхөн олговор	10,113,600.00	10,113,600.00	-	100.0%
Гэрээт ажлын хөлс	10,000,000.00	10,000,000.00	-	100.0%
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	31,782,700.00	31,636,454.03	146,245.97	99.5%
Тэтгэврийн даатгалын шимтгэл	20,225,400.00	20,214,395.11	11,004.89	99.9%
Тэтгэмжийн даатгал	2,311,500.00	2,310,216.59	1,283.41	99.9%
ҮОМШӨвчний даатгал	2,889,300.00	2,924,007.50	(34,707.50)	101.2%
Ажилгүйдлийн даатгал	577,900.00	492,933.37	84,966.63	85.3%
Эрүүл мэндийн даатгалын хураамж	5,778,600.00	5,694,901.46	83,698.54	98.6%
Тогтмол зардал	7,371,400.00	7,080,785.09	290,614.91	96.1%
Гэрэл цахилгаан	3,146,400.00	3,146,400.00	-	100.0%
Түлш, халаалт	2,400,000.00	2,399,202.27	797.73	100.0%
Цэвэр, бохир ус	1,000,000.00	710,182.82	289,817.18	71.0%
Байрны түрээс	825,000.00	825,000.00	-	100.0%
Хангамж, бараа материалын зардал	11,650,500.00	11,649,738.49	761.51	100.0%
Бичиг хэргийн зардал	1,231,700.00	1,231,700.00	-	100.0%
Тээвэр, шатахууны зардал	7,756,500.00	7,756,500.00	-	100.0%
Шуудан, харилцаа холбооны зардал	2,013,300.00	2,012,738.49	561.51	100.0%
Бага үнэтэй түргэн элэгдэх зүйлс	649,000.00	648,800.00	200.00	100.0%
Нормативт зардал	600,000.00	600,000.00	-	100.0%
Нормын хувцас, зөөлөн эдлэл худалдан авах зардал	600,000.00	600,000.00	-	100.0%
Эд хогшил худалдан авах	1,713,800.00	1,552,000.00	161,800.00	90.6%
Багаж, техник, хэрэгсэл	25,000.00	43,500.00	(18,500.00)	174.0%
Хөдөлмөр хамгааллын хэрэгсэл	720,000.00	720,000.00	-	100.0%
Урсгал засвар	968,800.00	788,500.00	180,300.00	81.4%
Томилолт, зочны зардал	2,057,600.00	2,057,000.00	600.00	100.0%
Дотоод албан томилолтын зардал	2,057,600.00	2,057,000.00	600.00	100.0%
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	9,388,000.00	9,385,360.00	2,640.00	100.0%
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	7,080,000.00	7,080,000.00	-	100.0%
Аудит, баталгаажуулалт зэрэглэл тогтоох зардал	1,500,000.00	1,500,000.00	-	100.0%
Даатгалын үйлчилгээ	300,000.00	297,360.00	2,640.00	99.1%
Тээврийн хэрэгслийн татвар	321,000.00	321,000.00	-	100.0%
Тээврийн хэрэгслийн оношилгоо	187,000.00	187,000.00	-	100.0%
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	44,348,900.00	16,464,038.00	27,884,862.00	37.1%
Бусад урсгал шилжүүлэг	44,348,900.00	16,464,038.00	27,884,862.00	37.1%
Тэтгэвэрт гарахад нь олгох нэг удаагийн мөнгөн	44,348,900.00	16,464,038.00	27,884,862.00	37.1%
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	397,844,700.00	397,576,940.00	267,760.00	99.9%
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	377,844,700.00	377,576,800.00	267,900.00	99.9%
Төсвөөс санхүүжих	377,844,700.00	377,576,800.00	267,900.00	99.9%
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	20,000,000.00	20,000,140.00	(140.00)	100.0%
Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	20,000,000.00	20,000,140.00	(140.00)	100.0%
Мөнгөн хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-	0.0%
Мөнгөн хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-	-	0.0%
Нийт ажиллагсдын тоо	35	35	-	100.0%
Удирдах ажилтан	1	1	-	100.0%
Гүйцэтгэх ажилтан	29	29	-	100.0%
Үйлчлэх ажилтан	5	5	-	100.0%